

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛИЙН
ХИЛИЙН АЛБАНЫ СУРГУУЛЬД
2023-2024 ОНЫ ХИЧЭЭЛИЙН ЖИЛД СУРАЛЦАХ ЭЛСЭЛТИЙН ЖУРАМ

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1. Энэхүү журмаар Дотоод хэргийн их сургууль /цаашид “ДХИС” гэх/-ийн 2023-2024 оны хичээлийн жилийн бакалаврын элсэлтийг зохион байгуулахтай холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Элсэлтийг зохион байгуулахад Боловсролын тухай хууль, Дээд боловсролын тухай хууль, Боловсрол, шинжлэх ухааны сайдын 2022 оны А/540 дүгээр тушаалаар баталсан “Оюутан элсүүлэх журам”, мөн сайдын 2023 оны “Босго оноо тогтоох тухай” А/97 дугаар тушаалын хавсралт, ДХИС-ийн захирлын 2021 оны А/222 дугаар тушаалхоёрдугаар хавсралтаар баталсан “Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам” бусад холбогдох акт болон энэхүү журмыг баримтална.

1.3. Элсэлтийн үйл ажиллагааг Нийслэлийн Баянзүрх дүүргийн 8 дугаар хороо, Хилчний гудамж /бүсчлэлийн код 13260/-д байрлах ДХИС-ийн байрлалд зохион байгуулна.

1.4. Бакалаврын хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоог захиалагч байгууллагын саналыг харгалзан тогтооно.

1.5. Элсэлтийн шалгалттай холбоотой мэдээллийг ДХИС-ийн “www.uia.gov.mn” цахим хуудсанд байршуулж, хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлнэ.

Хоёр. Элсэхийг хүсэгчид тавих шаардлага

2.1. Элсэхийг хүсэгч дараах нийтлэг шаардлагыг хангасан Монгол Улсын иргэнбайна:

2.1.1. Элсэхийг хүсэгчийн элсэлтийн ерөнхий шалгалт /цаашид “ЭЕШ” гэх/-ын оноо нь энэ журмаар тогтоосон босго онооноос багагүй байх;

2.1.2. ЭЕШ-ын батламж хүчинтэй байх (2021, 2022, 2023 он);

2.1.3. Хоёр жилийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь дараах мэргэжлээр бакалаврын боловсролтой, дипломын голч дүн 2.6-аас доошгүй байх;

- Эдийн засаг,
- Сэтгэл судлал,
- Нягтлан бодох бүртгэл,
- Санхүү, банк, даатгал,
- Байгалийн ШУ, математик, статистик,
- Мэдээлэл харилцаа холбооны технологи,
- Инженерчлэл,
- ХАА мал эмнэл зүй,
- Эрүүл мэнд,
- Цэрэг, батлан хамгаалах,
- Эрх зүй.

2.1.4. Элсэхийг хүсэгч нь Төрийн байгууллагуудын мэдээллийн санд байгаа өөрийн хувийн мэдээллийг албан хэрэгцээнд зориулан төрийн байгууллагуудын мэдээллийн систем хооронд дамжуулан ашиглахыг зөвшөөрсөн байх.

2.2. Элсэхийг хүсэгчид тавигдах тусгай шаардлага.

2.2.1. Бакалаврын 4 жилийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч эрэгтэй 17-25 хүртэл настай, эмэгтэй 17-20 хүртэл настай байх;

2.2.2. Бакалаврын 2 жилийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч эрэгтэй, эмэгтэй иргэн 26 хүртэл настай байх;

2.2.3. Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа хөтөлбөрт биеийн өндөр эрэгтэй 168-аас дээш, бусад 4 болон 2 жилийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч эрэгтэй биеийн өндөр 165 см-ээс дээш, эмэгтэй биеийн өндөр 163 см дээш байх;

2.2.4. Нэмэлт шалгалт /эрүүл мэнд, бие бялдар, сэтгэл зүйн сорил, ярилцлага/-д тэнцсэн байх;

2.2.5. Ял шийтгүүлж байгаагүй байх;

2.2.6. Дүрэмт хувцас (богино ханцуйтай цамц, футболк) өмссөн үед биеийн ил харагдах хэсэгт ямар нэг шивээсгүй байх (биеийн далдлагдах хэсэгт 50x30 мм-ээс томгүй хэмжээтэй шивээстэй байж болно.)

2.2.7. Өмнө нь ДХИС-ийн аль нэг хөтөлбөрт суралцаж сахилга, ёс зүйн зөрчлөөр сургалтаас хасагдаагүй байх;

2.2.8. Алба хаагчдад зориулсан 5 жилийн бакалаврын хөтөлбөрт элсэхийг хүсэгчдэд нас болон биеийн өндрийн тусгай шаардлага тавигдахгүй

Гурав. Элсэлт авах хөтөлбөр, босго оноо

| № | Бүрэлдэхүүн сургууль, институт | Хөтөлбөрийн нэр | Мэргэшүүлэх чиглэл, суралцах хугацаа | Элсэлтийн шалгалтын нэр, босго оноо | |
|--|---|---|--|-------------------------------------|----------------|
| | | | | Суурь /70%/ | Хавсарга /30%/ |
| 3.1. ЭЭШ-ын хичээлийн оноогоор болон ур чадварын шалгалтаар элсүүлэх хөтөлбөр | | | | | |
| 1 | Хил судлал | Хил судлал-Хилийн алба 4 жил | Нийгэм судлал -480 | Ур чадвар-480 | |
| 2 | | Хил судлал-Тусгай бэлтгэл 4 жил | Нийгэм судлал -480 | | |
| 3 | | Хил судлал-Сэтгэл зүйн хангалт 4 жил | Нийгэм судлал -480 | | |
| 4 | | Хил судлал-Ар тал хангалт 4 жил | Нийгэм судлал -480 | | |
| 5 | Хил хамгаалалтын зэвсэг, техникийн инженерчлэл 4 жил | Нийгэм судлал -480 | | | |
| 3.2. ЭЭШ-ын хоёр хичээлийн оноогоор элсүүлэх хөтөлбөр | | | | | |
| 6 | Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа | 4 жил | Нийгэм судлал -480 | Анли хэл -480 | |
| 3.4. Дээд боловсролтой иргэн элсүүлэх 2 жилийн хөтөлбөр | | | | | |
| 7 | Хил судлал | 2 жил | Бакалаврын дипломын голч дүн 2.6-аас дээш | | |
| 3.5. Алба хаагчдад зориулсан 5 жилийн хөтөлбөр | | | | | |
| 8 | Хил судлал | 5 жил | Нийгэм судлал -440 | Ур чадвар-480 | |

Дөрөв. Элсэлтийн бүртгэл

4.1. Энэ журмын 2-т заасан нийтлэг болон тусгай шаардлагыг хангасан элсэхийг хүсэгч ДХИС-ийн www.uia.gov.mn цахим хаяг руу нэвтэрч элсэлтийн цахим бүртгэл хэсэгт мэдээллээ биечлэн оруулах ба өргөдөл, эссээг PDF хэлбэрээр оруулна. Эссээ бичвэр нь “Миний сонгосон мэргэжил” сэдэвтэй, 1000-1500 үгтэй байна.

4.2. Элсэхийг хүсэгч нь энэ журмын 3 дугаар бүлэгт заасан хөтөлбөрүүдээс зөвхөн нэг хөтөлбөрийг сонгон бүртгүүлнэ.

4.3. Элсэхийг хүсэгч нь элсэлтийн бүртгэлд оруулсан мэдээллийн үнэн зөв байдлыг өөрөө хариуцах ба алдаатай, буруу мэдээлэл оруулснаас үүсэх асуудлыг ДХИС хариуцахгүй.

4.4. Элсэлтийн цахим бүртгэлийн санд бүртгүүлсэн мэдээллийг холбогдох баримт бичгүүдийн эх хувьтай тулган шалгах бөгөөд худал мэдүүлсэн тохиолдолд элсэлтийн бүртгэл болон тэнцсэн элсэхийг хүсэгчдийн жагсаалтаас хасна.

Тав. Элсүүлэх үе шат

5.1. Энэ журмын 3.1 дэх хэсэгт заасан хөтөлбөр (Хил судлал-Хилийн алба”, “Хил судлал-сэтгэл зүйн хангалт”, “Хил судлал-Ар талын хангалт”, “Хил хамгаалалтын зэвсэг техникийн инженерчлэл)-т суралцагч элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

| № | Үе шат | Эхлэх, дуусах хугацаа | Байрлал | Нэмэлт тайлбар |
|-------|---------------|--|-------------------|---|
| 5.1.1 | Цахим бүртгэл | 2023.04.10-ны 08.00 цагаас 2023.06.18-ны 17.00 цаг хүртэл | elselt.uia.gov.mn | Бүртгэл цахимаар явагдах бөгөөд аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй. |

| | | | | |
|-------|--|--|---|--|
| 5.1.2 | ЭЕШ-ын 1 хичээлийн оноогоор эрэмбэлж жагсаалт гаргана. | ЭЕШ-ын тов, дүн зарлах хугацаанаас шалтгаалан хугацааг тогтооно. | www.uia.gov.mn | Жагсаалтаар тэнцсэн болон тэнцээгүй иргэнд и-майл болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ. |
| 5.1.3 | Эрүүл мэндийн үзлэг шинжилгээ | | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг ТТАХНЭ, ДХИС | Эрүүл мэндийн үзлэг, шинжилгээг ТТАХНЭ-ийн комисс зохион байгуулна. |
| 5.1.4 | Ур чадварын шалгалт | | ДХИС | Шалгалтыг тухайлан томилогдсон комисс зохион байгуулна. Энэ журмын 6 дугаар бүлгийг үзнэ үү. |
| 5.1.5 | ЭЕШ-ын оноо болон ур чадварын шалгалтын онооны нийлбэрээр эрэмбэлж жагсаалт гаргана. | | ДХИС | Хөтөлбөрт элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгч нэмэлт шалгалтад орох эрх үүснэ. |
| 5.1.6 | Нэмэлт шалгалт Сэтгэл зүйн сорил | | ДХИС | Энэ журмын 7.2.3-г үзнэ үү. |
| 5.1.7 | Тэнцсэн элсэхийг хүсэгчдийн бүртгэл | | | Энэ журмын 5.3-т заасан материалыг бүрдүүлэн бүртгэлээ баталгаажуулна. |
| 5.1.8 | Хувцасны хангалт | | 07 сарын 21-22-ны өдөр 09.00-17.00 | Бүртгэл баталгаажуулсан элсэхийг хүсэгчдэд хувцасны хангалт олгоно. |
| | Нэмэлт шалгалт: (Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт) | | 07.25-аас 08-25-ны хооронд | Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв |
| 5.1.9 | Элсүүлэн суралцуулах, сонсогч цол олгох тухай тушаал гаргах | 2023.08.28 | ДХИС | Цэргийн тангараг өргөснөөр элсэлтэд тэнцсэнд тооцож Их сургуулийн захирлын тушаалаар элсүүлэн суралцуулна. |

5.2. Энэ журмын 3.2 дахь хэсэгт заасан хөтөлбөр ("Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа)-т суралцагч элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна:

| № | Үе шат | Эхлэх, дуусах хугацаа | Байрлал | Нэмэлт тайлбар |
|-------|--|--|---|---|
| 5.2.1 | Цахим бүртгэл | 2023.04.10-ны 08.00 цагаас 2023.06.18-ны 17.00 цаг хүртэл | elselt.uia.gov.mn | Бүртгэл цахимаар явагдах бөгөөд аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй. |
| 5.2.2 | Хөтөлбөрт элсүүлэн суралцуулах суурь болон хавсарга хичээлийн ЭЕШ-ын онооны нийлбэрээр, эрэмбэлж жагсаалт гаргана. | ЭЕШ-ын тов, дүн зарлах хугацаанаас шалтгаалан хугацааг тогтооно. | www.uia.gov.mn | Тэнцсэн болон тэнцээгүй иргэнд и-майл илгээх болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ. Тэнцсэн элсэхийг хүсэгч нэмэлт шалгалтад орох эрхтэй. |
| 5.2.3 | Нэмэлт шалгалт (Эрүүл мэнд) | | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг ТТАХНЭ, ДХИС | Эрүүл мэндийн үзлэгийг ТТАХНЭ-ийн комисс явуулна. (тэнцсэн бол нэмэлт шалгалтад орно) |
| 5.2.4 | Нэмэлт шалгалт (бие бялдар) | | ДХИС | Энэ журмын 7 дугаар бүлгийг үзнэ үү. |
| 5.2.5 | Нэмэлт шалгалт (сэтгэл зүйн сорил) | | | |

| | | | | |
|-------|--|---------------------------------------|---|--|
| 5.2.6 | Тэнцсэн элсэхийг хүсэгчдийн бүртгэл | | | Энэ журмын 5.3-т заасан материалыг бүрдүүлэн бүртгэлээ баталгаажуулна. |
| 5.2.7 | Хувцасны хангалт | 07 сарын 21-22-ны өдөр 09.00-17.00 | | Бүртгэл баталгаажуулсан элсэхийг хүсэгчдэд хувцасны хангалт олгоно. |
| 5.2.8 | Нэмэлт шалгалт (Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт) | 07.25-аас 08-25-ны хооронд | Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв | Энэ журмын 8 дугаар бүлгийг үзнэ үү. |
| 5.2.9 | Элсүүлэн суралцуулах, сонсогч цол олгох тухай тушаал гаргах | 2023.08.28 | ДХИС | Цэргийн тангараг өргөснөөр элсэлтэд тэнцсэнд тооцож Их сургуулийн захирлын тушаалаар элсүүлэн суралцуулна. |

5.3. Энэ журмын 3.1, 3.2-т заасан хөтөлбөрт тэнцсэн тухай мэдэгдэл хүлээн авсан элсэхийг хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн тогтоосон хугацаанд биечлэн ирж бүртгүүлнэ:

- 5.3.1. иргэний үнэмлэх, хуулбарын хамт
- 5.3.2. бүрэн дунд боловсролын гэрчилгээ эх хувь;
- 5.3.3. элсэлтийн ерөнхий шалгалтын батламжийн эх хувь;
- 5.3.4. цээж зураг - 3x4 хэмжээтэй 2 хувь;
- 5.3.5. эрүүл мэндийн үзлэгийн хуудас;

5.4. Энэ журмын 3.4-д заасан “Хил судлал” 2 жилийн хөтөлбөрт элсэх бакалаврын боловсрол эзэмшсэн иргэнийг элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна.

| № | Үе шат | Эхлэх, дуусах хугацаа | Байрлал | Нэмэлт тайлбар |
|-------|--|---|---|--|
| 5.4.1 | Цахим бүртгэл | 2023.05.01-ний 08.00 цагаас 2023.06.15-ны 17.00 цаг хүртэл | elselt.uia.gov.mn | Бүртгэл цахимаар явагдах бөгөөд аймаг, орон нутагт тусгайлсан бүртгэл явагдахгүй. |
| 5.4.2 | Бакалаврын дипломын голч дүнгээр эрэмбэлж жагсаалт гаргах | 2023-06-16 09.00-17.00 | www.uia.gov.mn | Бакалаврын дипломын хүчинтэй эсэхийг шалгана. |
| 5.4.3 | Эрүүл мэндийн үзлэг | | Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг ТТАХНЭ, ДХИС | Энэ журмын 7.2.1-ийг үзнэ үү. |
| 5.4.4 | Нэмэлт шалгалт (бие бялдар) | 2023.06.22- 2023.07-01 | ДХИС | Энэ журмын 7 дугаар бүлгийг үзнэ үү. Энэ журмын 5.8-д заасан материалыг бүрдүүлэн бүртгэлээ баталгаажуулна. |
| 5.4.5 | Нэмэлт шалгалт (сэтгэл зүйн сорил) | | | |
| 5.4.6 | Тэнцсэн элсэхийг хүсэгчдийн бүртгэл | | | |
| 5.4.7 | Хувцасны хангалт | | | |
| 5.4.8 | Нэмэлт шалгалт (Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт) | 07.25-аас 08-25-ны хооронд | Гүнжийн хоолой дахь сургалт, дадлагын төв | Энэ журмын 8 дугаар бүлгийг үзнэ үү. |
| 5.4.9 | Элсүүлэн суралцуулах, сонсогч цол олгох тухай тушаал гаргах | 2023.08.28 | ДХИС | Цэргийн тангараг өргөснөөр элсэлтэд тэнцсэнд тооцож Их сургуулийн захирлын тушаалаар элсүүлэн суралцуулна. |

5.5. Дээрх хөтөлбөрт тэнцсэн тухай мэдэгдэл хүлээн авсан элсэхийг хүсэгч дараах баримт бичгийг бүрдүүлэн тогтоосон хугацаанд биечлэн ирж бүртгүүлнэ:

- 5.5.1. иргэний үнэмлэх, хуулбарын хамт

5.5.2. бакалаврын диплом, хавсралт (эх хувь);

5.5.3. цээж зураг - 3x4 хэмжээтэй 2 хувь;

5.5.4. эрүүл мэндийн үзлэгийн хуудас;

5.6. Энэ журмын 3.5-д заасан алба хаагчдад зориулсан 5 жилийн хөтөлбөр “Хил судлал”-т элсэх алба хаагчдыг элсүүлэх ажлыг дараах үе шаттай зохион байгуулна.

| № | Үе шат | Эхлэх, дуусах хугацаа | Нэмэлт тайлбар |
|-------|--|--|---|
| 5.6.1 | Цахим бүртгэл | 2023.05.01-ний 08.00 цагаас 2023.06.15-ны 17.00 цаг хүртэл | Энэ журмын 4 дүгээр бүлгийг үзнэ үү. Энэ журмын 9.4-д заасан шалгуур хангасан алба хаагч нь эрхэлж буй албан тушаал, ажилласан жилийг тодорхойлсон албан бичиг, нийгмийн даатгал төлсөн лавлагаа (5 жилээр)-г тус тус бүртгэлийн хэсэгт зөвхөн PDF хэлбэрээр оруулна. |
| 5.6.2 | Элсэлтийн ерөнхий шалгалтын суурь шалгалтын оноогоор буурах эрэмбээр жагсаалт гаргах | ЭЭШ-ын тов, дүн зарлах хугацаанаас шалтгаалан элсэлтийн шалгалтын хугацааг тогтооно. | ЭЭШ-ын суурь хичээлийн босго оноог давсан элсэхийг хүсэгчийг онооны эрэмбээр жагсааж тэнцсэн, тэнцээгүй тухай и-майл илгээх болон гар утсанд 135038 дугаараас мессеж илгээж мэдэгдэнэ. Тэнцсэн элсэхийг хүсэгчид ур чадварын шалгалтад орох эрх үүснэ. |
| 5.6.3 | Ур чадварын шалгалт | 2023.06.28-ны дотор | Ур чадварын шалгалтыг тухайлсан комисс зохион байгуулна. Энэ журмын 6 дугаар бүлгийг үзнэ үү. |
| 5.6.4 | Тэнцсэн элсэхийг хүсэгчийн нэрсийг захиалагч байгууллагад хүргүүлэх | 2023.07.01-ний дотор | ЭЭШ-ын оноо, ур чадварын шалгалтаар тэнцсэн болон энэ журмын 9.4-д заасан шалгуурыг хангасан элсэхийг хүсэгчдийг хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтаан захиалагч байгууллагын саналыг харгалзан элсүүлнэ. |
| 5.6.5 | Захиалагч байгууллагаас тэнцсэн элсэхийг хүсэгчийн бичиг баримтыг хүлээн авах | | Захиалагч байгууллагаас суралцуулах элсэхийг хүсэгчийн нэрс, суралцахыг дэмжсэн даргын тушаал, хурлын тэмдэглэл, албан бичгийг хүлээн авна. |
| 5.6.6 | Элсүүлэн суралцуулах тухай тушаал гаргах | 2023.07 сарын 3 дугаар долоо хоногт | Бакалаврын хөтөлбөрт элсүүлэн суралцуулах тухай Комиссын саналыг үндэслэн Их сургуулийн захирал тушаал гаргана. |
| 5.7.7 | Элсүүлэн суралцуулах тухай тушаалыг захиалагч байгууллагад хүргүүлэх | | |

5.8. Алба хаагчдад зориулсан 5 жилийн хөтөлбөрт элсэгчдээс нэмэлт шалгалт авахгүй.

Зургаа. Ур чадварын шалгалт

6.1. Энэ журмын 3.1, 3.5 дахь хэсэгт заасан хөтөлбөрт элсэхийг хүсэгч нь эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний дүгнэлтээр тэнцсэн бол ур чадварын шалгалтад хамрагдана.

6.2. Шалгалтыг Их сургуулийн захирлын тушаалаар баталсан комисс удирдамжийн дагуу зохион байгуулна.

6.2. Ур чадварын шалгалтыг удирдамжид заасан шалгуураар 5 чанарын авбал зохих 100 онооноос чанар тус бүрийн нийлбэр 60 хувь буюу түүнээс дээш оноо авсан тохиолдолд тэнцэнэ.

6.4. Ур чадварын шалгалтыг 0-100 оноогоор арваны орны нарийвчлалтайгаар үнэлнэ. Энэхүү үнэлгээ нь анхны оноо болно.

6.5. Анхны онооны гүйцэтгэлийн хувиар хэмжээст оноог тооцож гаргана. Хэмжээст оноог дараах аргачлалаар бодно.

| № | Анхны оноо (А) | Хэмжээст оноо (Х) | Бодох томъёо |
|---|----------------|-------------------|------------------|
| 1 | 0-59 | 200-479 | $X=200+A*4.66$ |
| 2 | 60-64.9 | 480-519 | $X=480+(A-60)*8$ |
| 3 | 65-69.9 | 520-559 | |
| 4 | 70-74.9 | 560-599 | |
| 5 | 75-79.9 | 600-639 | |
| 6 | 80-84.9 | 640-679 | |
| 7 | 85-89.9 | 680-719 | |
| 8 | 90-94.9 | 720-759 | |
| 9 | 95-100 | 760-800 | |

6.6. Ур чадварын шалгалтын оноо (30 хувь) болон ЭЕШ-ын оноо (70 хувь)-ны нийлбэрийг үндэслэн буурах дарааллаар эрэмбэлэн хөтөлбөр тус бүрээр элсүүлэх хяналтын тоонд багтсан элсэхийг хүсэгчийг дараагийн нэмэлт шалгалтад оруулна.

Долоо. Элсэлтийн нэмэлт шалгалт

7.1. Дараах элсэхийг хүсэгчдийг нэмэлт шалгалт, судалгаанд хамруулна. Үүнд:

7.1.1. Энэ журмын 3.1, 3.2 дахь хэсэгт заасан хөтөлбөрт бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдийг хөтөлбөр тус бүрээр ЭЕШ-ын оноог буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоог 40 хувь хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэхийг хүсэгч; (*хяналтын тоо 100 байх тохиолдолд элсэхийг хүсэгчдийн жагсаалтын эхний 140-д багтсан элсэхийг хүсэгч*)

7.1.2. Энэ журмын 3.4 дэх хэсэгт заасан 2 жилийн хөтөлбөрт бүртгүүлсэн элсэхийг хүсэгчдийг хөтөлбөрт тус бүрээр дипломын голч дүнгийн буурах эрэмбээр жагсааж, хяналтын тоог 30 хувь хүртэл нэмэгдүүлсэнтэй тэнцэх тооны элсэхийг хүсэгч (*хяналтын тоо 100 байх тохиолдолд элсэхийг хүсэгчдийн жагсаалтын эхний 130-д багтсан элсэхийг хүсэгч*) нэмэлт шалгалтад хамрагдана.

7.2. Нэмэлт шалгалтын төрөл:

| № | Нэмэлт шалгалт | Шалгуур үзүүлэлт |
|-------|---|---|
| 7.2.1 | “Эрүүл мэндийн үзлэг”-ийг Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлгийн нарийн мэргэжлийн эмч нарын бүрэлдэхүүнтэй баг зохион байгуулна. | - Эрүүл мэндийн хувьд цэргийн албанд тэнцэх (Засгийн газрын 2019 оны 441 дүгээр тогтоол) -биеийн далдлагдах хэсэгт 50x30 мм-ээс томгүй хэмжээтэй шивээстэй байж болно -бие эрхтний зөв хөгжилтэй, биеийн ил харагдах хэсэгт 20x10 мм-ээс том сорвигүй байх; -мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисын хамааралгүй байх; -Эрүүл мэндийн нарийвчилсан үзлэг, шинжилгээ өгч дүгнэлт гаргуулсан байх (ТТАХНЭ) |
| 7.2.2 | Бие бялдрын шалгалт | Хүч, тэсвэр, уян хатан, хурд, авхаалж самбаа гэсэн 5 чанар тус бүрээр зохих шалгуур хангасан байх; |
| 7.2.3 | Сэтгэл зүйн сорил, ярилцлага | Сэтгэцийн эрүүл мэнд, сэтгэн бодох чадвар, мэргэжлийн сонголт хийж буй сэтгэл зүйн хандлагын түвшинг тодорхойлно. |
| 7.2.4 | Цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалт | Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад тэнцэж тангараг өргөсөн байх; журмын 6-г үзнэ үү. |

7.3. Эрүүл мэндийн үзлэгт тэнцсэн элсэхийг хүсэгчийг бие бялдрын нэмэлт шалгалтад хамруулна.

7.4. Бие бялдрын шалгалтыг энэ журмын 6 дугаар бүлэг дэх ур чадварын шалгалтын удирдамжид заасан шалгуурын дагуу зохион байгуулна. Бие бялдрын шалгалтад тэнцээгүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасаж, дараагийн нэмэлт шалгалтад оруулахгүй.

7.5. Сэтгэл зүйн сорилд тэнцээгүй элсэхийг хүсэгч нарийн мэргэжлийн шинжилгээнд хамрагдаж дүгнэлт гаргуулж болно.

Найм. Цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалт

8.1. Нэмэлт шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчийг цэргийн хэргийн анхан шатны мэдлэг олгох сургалтад /цаашид “ЦХАШМОС” гэх/ хамруулна.

8.2. ЦХАШМОС-ыг Их сургуулийн Сургалт, дадлагын төвд 2023 оны 08 дугаар сарын 25-ны дотор багтаан 4-өөс доошгүй долоо хоногийн хугацаатай зохион байгуулна.

8.3. ЦХАШМОС-д хамрагдах элсэхийг хүсэгчид дараах баримт бичгийг бүрдүүлсэн байна.Үүнд:

8.3.1. эрүүл мэндийн даатгалын дэвтэр /2023 оны 09 дүгээр сар хүртэл хугацааны даатгалыг бүрэн төлсөн байх/;

8.3.2. гэнэтийн ослын даатгалд даатгуулсан баримт;

8.4. ЦХАШМОС-д явах цуваа хөдлөх цагт ирээгүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасаж, олгосон хувцас хэрэгслийн үнийг төлүүлнэ.

Ес. Хөнгөлөлт үзүүлэх нөхцөл

9.1. Төрийн тусгай албанд үүрэг гүйцэтгэж байгаад нас барсан, хөдөлмөрийн чадвараа 100 хувь алдсан алба хаагчийн гэр бүлийн хамаарал бүхий этгээд босго онооны шалгуурыг хангасан бол элсэн суралцахад дэмжлэг үзүүлж болно.

9.2. ДХИС-д ажиллаж байгаа багш, алба хаагчийн энэ журмын 2 дугаар бүлэгт заасан нийтлэг болон тусгай шаардлага хангасан хүүхдийг элсүүлэн суралцуулахад дэмжлэг үзүүлж болно. Урьд нь 4 жилийн дотор дэмжлэг авсан алба хаагчийн хүсэлтийг хүлээн авахгүй.

9.3. Алба хаагчдад зориулсан 5 жилийн хөтөлбөрт Хил хамгаалах байгууллагад 5-аас доошгүй жил ажилласан, 30-аас дээш настай алба хаагчийг нотлох баримтыг үндэслэн шалгалтгүйгээр элсүүлнэ.

Арав. Элсэлтийн шалгалтын комисс

10.1. Элсэлтийн үйл ажиллагааг Элсэлтийн шалгалтын комисс /цаашид “Комисс” гэх/ зохион байгуулна. Комиссын бүрэлдэхүүнийг захиалагч агентлаг, байгууллагын төлөөллийг оролцуулан Их сургуулийн захирлын тушаалаар батална.

10.2. Комисс болон комиссын дарга Их сургуулийн захирлын 2021 оны А/222 дугаартушаалаар баталсан “Бакалаврын сургалтын элсэлт зохион байгуулах журам”-д заасан чиг үүрэг, бүрэн эрх, үүргийг хэрэгжүүлнэ.

10.3. Комиссын дарга энэ журмаар зохицуулагдаагүй асуудлыг комиссын хурлаар хэлэлцэж шийдвэрлэнэ.

Арван нэг. Элсүүлэх шийдвэр гаргах

11.1. Комиссын хуралдаанаар элсэлтийн шалгалтын дүнг хэлэлцэн, шалгуур хангаж, шалгалтад тэнцсэн элсэхийг хүсэгчийг сонгосон хөтөлбөрт элсүүлэн суралцуулах саналыг Их сургуулийн захиралд танилцуулна.

11.2. Комиссын саналыг үндэслэн Их сургуулийн захирал тушаал гаргана.

11.3. Цэргийн хэргийн анхан шатны сургалтад хамрагдаагүй, сургалтын явцад хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сургалтыг орхисон, сахилгын зөрчил гаргасан, сургалтын төвийн даргын зөвшөөрөлгүй байрлалыг орхин явсан, өөрийн хүсэлтээр сургалтаас чөлөөлөгдөх хүсэлт гаргасан болон цэргийн тангараг өргөөгүй элсэхийг хүсэгчийг элсүүлэн суралцуулахгүй.

Арван хоёр. Элсэлтийн шалгалтын зардал

12.1. Элсэхийг хүсэгч дор дурдсан зардлыг хариуцна:

12.1.1. эрүүл мэндийн үзлэг, шинжилгээний төлбөр;

12.1.2. гэнэтийн ослын даатгалын төлбөр;

12.1.3. цэргийн хэргийн бэлтгэл сургалттай холбоотой зардал;

12.1.4. сургалтын удирдлага мэдээллийн систем ашиглалтын төлбөр;

12.2. Энэ журмын 11.3-т заасан тохиолдолд сургалтын явцад гарсан зардал болон их сургуулиас тавьж олгосон хувцас хэрэглэл, хоол хүнсний зардлыг элсэхийг хүсэгч төлөх үүрэгтэй.

12.3. Энэ журамд заагаагүй төлбөр, хураамж, хандив авахыг хориглоно.

Арван гурав. Өргөдөл, гомдол шийдвэрлэх

13.1. Элсэлттэй холбоотой өргөдөл, гомдлыг 07 дугаар сарын 20-ны өдрийг хүртэл, цэргийн хэргийн анхан шатны бэлтгэл сургалттай өргөдөл, гомдлыг 08 дугаар сарын 25-ны өдрийг хүртэл тус тус хүлээн авна.

13.2. Өргөдөл, гомдлыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 хоногт багтаан шийдвэрлэнэ. Шаардлагатай тохиолдолд уг хугацааг Их сургуулийн захирал 5 хүртэл хоногоор нэмж сунгаж болно. Хугацаа сунгасан тухай өргөдөл, гомдол гаргагчид мэдэгдэнэ.

13.3. Өргөдөл, гомдлыг хариуг биечлэн амаар буюу утсаар эсхүл бичгээр мэдэгдэнэ. Хариуг амаар, утсаар мэдэгдсэн алба хаагч энэ тухай тэмдэглэл үйлдэж материалд хавсаргана.

Арван дөрөв. Сургалтын төлбөр, төлөх зарчим

14.1. Бакалаврын өдрийн хөтөлбөрт элсэхийг хүсэгч Сургалтын удирдлага, мэдээллийн систем хэрэглэгчийн төлбөрийг 2023оны 08 дугаар сарын 30-ны дотор төлнө.

14.2. Элсэхийг хүсэгч нь зохих шаардлага хангасан бол төрийн болон бусад байгууллагаас олгодог сургалтын төлбөрийн тэтгэлэг, зээлд хамрагдаж болно.

Арван тав. Бусад зүйл

15.1. Элсэлтийн цахим бүртгэлд бүртгүүлсэн иргэдэд “тэнцсэн” болон “тэнцээгүй” тухай бүртгэгдсэн гар утас болон и-мэйл хаягаар мэдэгдэнэ. Тэнцсэн тухай мэдэгдэл авсан элсэхийг хүсэгч заасан хугацаанд ирж нэмэлт шалгалтад ороогүй, эрх зүй хөтөлбөрт элсэхийг хүсэгч 5.4.3-т заасан хугацаанд бүртгүүлээгүй бол элсэхийг хүсэгчийн жагсаалтаас хасна.

15.2. Элсэхийг хүсэгч нь БШУЯ-аас тогтоосон үндэсний хэмжээний ЭЭШ-ын босго оноог хангасан боловч энэ журмаар тогтоосон тухайн хөтөлбөрт хамаарах босго онооны шаардлага хангаагүй бол элсүүлэхгүй.

15.3. Нэмэлт шалгалтад тэнцсэн боловч бүртгүүлсэн хөтөлбөрийн хяналтын тоонд багтаагүй элсэхийг хүсэгчийг бүртгэлээс хасна.

15.4. Элсэлтийн шалгалтын комисс нь энэ журмын 15.3-т заасны дагуу хасагдсан элсэхийг хүсэгчид хяналтын тоонд хүрээгүй хөтөлбөрт бүртгүүлэхийг санал болгож болно.

15.5. Элсэхийг хүсэгчийн иргэний болон боловсролын үнэмлэх, диплом, бусад баримт бичиг засвартай, хуурамч байж болзошгүй тохиолдолд элсэхийг хүсэгчдийн жагсаалтаас хасаж, харьяаллын дагуу шалгуулахаар шилжүүлнэ.

ЭЛСЭЛТ АВАХ БАКАЛАВРЫН ХӨТӨЛБӨРИЙН ХЯНАЛТЫН ТОО

| д/д | Хөтөлбөрийн нэр | Суралцах хугацаа, хэлбэр | Элсүүлэх хяналтын тоо | Хүйс | |
|---|--|--------------------------|-----------------------|---------|---------|
| | | | | Эрэгтэй | Эмэгтэй |
| 1 | Хил судлал-Хилийн алба | 4 жил /өдөр/ | 25 | 25 | - |
| 2 | | 2 жил /өдөр/ | 25 | 15 | 10 |
| 3 | Хил судлал-Тусгай бэлтгэл | 4 жил /өдөр/ | 15 | 15 | - |
| 4 | Хил судлал-Сэтгэл зүйн хангалт | | 15 | 10 | 5 |
| 5 | Хил судлал-Ар талын хангалт | | 15 | 10 | 5 |
| 6 | Хил хамгаалалтын зэвсэг, техникийн инженерчлэл | | 20 | 20 | - |
| 7 | Шалган нэвтрүүлэх үйл ажиллагаа | | 45 | 25 | 20 |
| Алба хаагчдад зориулсан 5 жилийн хөтөлбөр | | | | | |
| 8 | Хил судлал-Хилийн алба | 5 жил /эчнээ/ | 25 | 15 | 10 |

ДОТООД ХЭРГИЙН ИХ СУРГУУЛЬ